**МОНГОЛ УЛС**
**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2022 оны 01 сарын 11 өдөр | Дугаар А/01 | Алтай хот

## Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Үнэлгээний хорооны 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 119 дүгээр зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ГААСЗДТГ/202109018 дугаартай бохир соруулах автомашин нийлүүлэх ажлыг “Эй Кэй Юу” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Алтай сумын Засаг даргын Тамгын газар (Н.Батбаяр)-т олгосугай.

2.Гүйцэтгэгчийн санал болгосон ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Алтай сумын Засаг даргын Тамгын газар (Н.Батбаяр)-т үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Алтай сумын Засаг дарга (Д.Эрдэнэжаргал)-д тус тус даалгасугай.

ОРЛОГЧ Д.АЛТАНЗАГАС

C:/My documents/-3A-4 doc

0205000780